

ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТЭД НОТЛОХ БАРИМТЫН ТУСГАЙ ШААРДЛАГА ТАВИХ АСУУДАЛ

THE PROBLEM OF ISSUING SPECIAL CRITERIA FOR THE ADMISSION OF EVIDENCE IN THE TESTIMONY OF FORENSIC EXPERTS

БЛХАГВАСҮРЭН

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Шинжлэн магадлахуйн тэнхимийн дэд профессор, цагдаагийн хошууч

LKHAGVASUREN B.

(Police Major)

Associate Professor at the Forensic Science Faculty of the Police School, Law Enforcement University

Товч агуулга: Шүүгч болон өмгөөлөгчдийн ихэнх нь шинжлэх ухаан, техникийн мэдлэгийн хувьд тусгайлан бэлтгэгдээгүй байдаг тул шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд тодорхой бэрхшээлтэй тулгардаг. Гэвч тэд шинжээчийн дүгнэлтийг ашиглаж шийдвэр гаргах шаардлагатай болдог. Иймээс шинжээчийн дүгнэлтийг хэрхэн үнэлэх талаар энэ өгүүлэлд дурдсан болно.

Abstract: The use of scientific evidence in a forensic setting has proven problematic for both judges and attorneys because most of them are not technically trained. Much of the difficulty encountered by courts when facing scientific evidence lies not in a lack of understanding the underlying science but in the task of choosing between competing scientific explanations tendered by individuals who seek to wear the mantle of experts.

Түлхүүр үгс: Шинжлэн магадлах ухаан, шинжээч, дүгнэлт, шинжлэх ухааны нотлох баримт, шалгуур.

Keywords: forensic science, forensic expert, opinion, scientific evidence, criteria

Удиртгал

Үндсэн хуулийн болон эрүү, иргэн, захиргааны процессын хууль тогтоомжид шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг нотлох баримтын эх сурвалж мөн болохыг зааж өгсөн. Түүнчлэн нотлох баримтад тавих шаардлагын талаар дээрх хууль тогтоомж, процессын эрх зүйн онолын сурах бичигт тодорхойлсон байдаг.

Шинжээчийн дүгнэлт нь харьцангуй бодитой, нотлох баримтын онцгой шинж бүхий эх сурвалж мөн¹ тул нотлох баримтад эрх зүйн үндсэн асуудлууд. УБ., 2008. 145 дах тал.


тавих нийтлэг шаардлагаас гадна тусгай шалгуураар үнэлэх асуудал чухал болохыг танилцуулах нь энэ өгүүллийн зорилго юм.

Өгүүллийг бэлтгэхэд статистик тоо баримтад дүн шинжилгээ хийх, шинжилгээ хийлгэх эрх бүхий албан тушаалтнаас санал асуулга авах, фокус ярилцлага хийх, шинжээчийн дүгнэлтийг үнэлэх онол, арга зүйтэй холбоотой онолын ойлголтуудыг харьцуулах зэрэг судалгаа хийв.

Үндсэн хэсэг

Монгол Улсын шүүхийн практикт шинжээчийн дүгнэлт ашиглаж буй өнөөгийн байдлыг дараах статистик тоо баримтаас харж болно.

График №1. 2009-2016 онд шүүхийн шинжилгээний байгууллагаас хийсэн шинжилгээ




Дээрх графикаас шинжилгээний тоо тасралтгүй өссөн үзүүлэлт харагдаж байх ба сүүлийн гурван онд 65000 дээш шинжилгээ хийсэн байна.

Мөн улсын хэмжээнд бүртгэгдсэн эрүү, иргэн, захиргааны хэргийг шинжилгээний тоотой харьцуулах шаардлагатай гэж үзлээ.

График №2. Улсын хэмжээнд 2014-2016 онуудад бүртгэгдсэн гэмт хэрэг болон




МОНГОЛ
УЛСЫН
ХУУЛЬ
САХИУЛАХ
УРСАЛ




2014 онд 1 гэмт хэрэг тутамд 2.2 шинжилгээ, 2015 онд 1 гэмт хэрэг тутамд 2.2 шинжилгээ, 2016 онд 1 гэмт хэрэг тутамд 2.3 шинжилгээ оногдож байна.

График №3. Улсын хэмжээнд 2014-2016 онуудад анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэг болон иргэний хэрэгт хийсэн шинжилгээ³



2014 онд 50.2 иргэний хэрэгт 1 шинжилгээ, 2015 онд 53.2 иргэний хэрэгт 1 шинжилгээ, 2016 онд 32.3 иргэний хэрэгт 1 шинжилгээ хийсэн байна.

График №4. Улсын хэмжээнд 2014-2016 онуудад анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн захиргааны хэрэг болон захиргааны хэрэгт хийсэн шинжилгээ⁴



2014 онд 19.4 захиргааны хэрэгт 1 шинжилгээ, 2015 онд 31.2 захиргааны хэрэгт 1 шинжилгээ, 2016 онд 10.5 захиргааны хэрэгт 1 шинжилгээ хийсэн байна.

Дээрх 3 графикаас эрүүгийн хэрэгт хийлгэх шинжилгээ тогтмолжсон, харин 2016

онд иргэний хэргийн шүүх өмнөх оноос 1.8 дахин их, захиргааны хэргийн шүүх өмнөх оноос 3.6 дахин их шинжилгээ хийлгэсэн гэж харагдаж байна. Энэ нь шүүхийн шинжлэх ухаанч хандлага нэмэгдсэн гэж дүгнэхэд хүргэж байна.

График №5. Шинжилгээ хийлгэх эрх бүхий байгууллага, субъектийн харьцаа⁵



Шүүхийн шинжилгээний байгууллагаар хийлгэсэн нийт шинжилгээний 98 гаруй хувийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокуророос томилсон, түүнчлэн нийт шинжилгээний 98 гаруй хувийг эрүүгийн хэрэгт хийсэн байна.

Статистик тоо баримтаас дүгнэвэл, нэгдүгээрт, гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх ажиллагаанд шинжээчийн дүгнэлт ашиглах туршлага иргэн, захиргааны процессыг бодоход илүү хуримтлуулсан, хоёрдугаарт, Эрүүгийн байцаан шийтгэх (цаашид “ЭБШ” гэх) хуульд заасан шинжилгээ заавал хийлгэх тохиолдол эрүүгийн хэрэгт хийсэн шинжилгээний тооноос хамааралтай гэж үзэж байна.

Харин иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд шинжээчийн дүгнэлтийг хангалтгүй ашиглаж байна. Энэ нь тухайн процессын нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагааны онцлогтой холбоотой гэж ойлгож болно.

Хэдийгээр гэмт хэрэг шалгаж, шийдвэрлэхэд шүүх шинжээчийн дүгнэлтийг түгээмэл ашиглаж байгаа боловч шинжээчийн дүгнэлтийг үнэлэх арга зүйд тулгамдсан асуудал байна.

Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх практикийг тодруулах үүднээс явуулсан⁶ санал асуулгын судалгааны “ЭБШХ-ийн 85 дугаар зүйлийн 85.4-т зааснаар шинжээчийн дүгнэлтийг заавал баримтлах үүрэггүй боловч дүгнэлтийг зөвшөөрөхгүй байгаа үндэслэлээ хэрхэн тодорхойлдог вэ?” гэсэн асуултад 71.4 хувь нь “Энэ бол дотоод итгэлийн асуудал” гэж, 28.6 хувь

⁵ ШШҮХ-ийн тайлангаас авав.

⁶ Шинжилгээ хийлгэх эрх бүхий 50 албан тушаалтнаас санал асуулгын судалгаа авав.

² ЦЕГ-ын Мэдээлэл судалгааны төв болон ШШҮХ-ийн тайлангаас авав.

³ ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн болон ШШҮХ-ийн тайлангаас авав.

⁴ ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн болон ШШҮХ-ийн тайлангаас авав.

нь “тодорхой шалгуур хангахгүй байгааг ойлгоно” гэж хариулсан. Мөн “Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх стандарт шалгуурын талаар та юу мэдэх вэ?” гэсэн асуултад судалгаанд хамрагдагсдын 78.5 хувь нь “мэдэхгүй” гэж, 21.5 хувь нь “ЭБШХ-ийн 95-р зүйлд заасан шаардлага” гэж хариулжээ.

Санал асуулгын судалгаанаас үзвэл, шинжээчийн дүгнэлтийг баримтлах, эс баримтлахаа дотоод итгэлээр үнэлдэг гэсэн хэдий ч, яаж дотоод итгэлтэй болдог талаараа мэдэхгүй байгаа нь сонирхол татаж байна. Эндээс процесс хэрэгжүүлэгчид шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд учир дутагдалтай байна гэж дүгнэж болохоор байна.

ЭБШ эрх зүйн сурах бичгүүдэд⁷ аливаа нотлох баримтыг үнэлэхдээ: 1) зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх үнэлнэ, 2) тэд нотлох баримтыг дотоод итгэлээрээ үнэлнэ, 3) урьдаас хөдөлшгүй үнэн гэж тогтоосон ямар ч нотлох баримт байх ёсгүй, бусад баримтуудаар батлагдаж байх ёстой, 4) хуульд заасан журам арга хэрэгслээр цуглуулсан байх, тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, хангалттай, **үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлэлт өгнө гэсэн нийтлэг үндэслэл, зарчмыг онолын хувьд тодорхойлжээ.**

ЭБШ хуулийн 85 дугаар зүйлийн 85.4-д “Шинжээчийн дүгнэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор шүүх заавал баримтлах үүрэггүй боловч дүгнэлтийг зөвшөөрөхгүй байгаа бол үндэслэлээ заасан байвал зохино”⁸ гэсэн нь шинжээчийн дүгнэлтийг үнэлэх эрх зүйн үндэс.

Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх онолын болоод хууль зүйн үндэслэл байгаа хэдий ч, шинжээчийн дүгнэлтийг “шүтэх”, эсвэл тодорхой үндэслэл тоочихгүйгээр “үгүйсгэх” байдал практикт байсаар байгаа⁹ нь хэргийн бодит үнэнийг тал бүрээс нь бүрэн дүүрэн тогтоох ЭБШ ажиллагааны зорилт болоод нотлох баримт үнэлэх зарчимд харшилна. **Жишээ нь:** - ЧД-ийн шүүгч 2 удаа шинжээч томилсон байх бөгөөд шинжээчийн дүгнэлтүүд хоорондоо зөрсөн тул нотлох баримт болохгүй гэж гэрчийн мэдүүлгээр хэрэг шийдсэн байна.

- СХД-ийн шүүгч иргэний нэг хэрэгт 4 удаа шинжээч томилж шинжилгээ хийлгэсэн бөгөөд шинжээчийн дүгнэлтүүд зөрүүтэй

⁷ Хамтын бүтээл. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар. УБ., 2003. 108 дахь тал.

- Ж.Бямбаа. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд. УБ., 2008. 133 дахь тал.

⁸ Эрүүгийн байцаан шийтгэх хууль. //Төрийн мэдээлэл. 2002. №6.

⁹ Санал асуулгын хуудас болон хавтаст хэрэгт хийсэн судалгаа.

гарсан нь хуульд зааснаар нотлогдохгүй байх тул нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон шийдвэр гаргасан байна. Энэ тохиолдолд шинжээчийн дүгнэлт шинжлэх ухааны үндэслэлтэй гарсан эсэх талаар үнэлэлт өгөлгүй, харин шинжээчийн дүгнэлтийг шинжээчийн тоогоор талцуулж, дүгнэлтийн үнэлэмжийг бууруулж байгаа нь энэ жишээнээс харагдаж байна

Шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд бусад нотлох баримттай харьцуулах ёстой гэж үздэг. Гэвч шинжээчийн дүгнэлт бусад баримттай давхцаж байгаа бол бодитой дүгнэлт гарсан байна гэж үзэх нь өрөөсгөл ойлголт. Харин тухайн шинжээчийн дүгнэлтийг тодорхой шалгуураар үнэлснээр бодит, зөв дүгнэлт гарсан эсэхийг тогтооно. Түүнээс биш бусад баримтуудтай харьцуулж үзсэнээр бодит үнэлгээ хийлээ гэж болохгүй. Энэ тухай Р.С.Белкин, Ю.Г.Корухов нар “шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ бусад нотлох баримттай харьцуулж үзэх ёстой гэсэн үзэл баримтлал нь шинжээчийн дүгнэлтийг бодитой дүгнэх чадваргүй байгааг харуулж байгаа явдал” гэсэн байдаг.

Шүүхийн шийдвэр үнэн, бодитой байх гол үзүүлэлт нотлох баримтыг зөв үнэлэх асуудал. Энэ ч утгаараа шинжээчийн дүгнэлтийн найдвартай, баталгаатай, шинжлэх ухаанч байдал нь хүний эрх, эрх чөлөөг хангах зүй тогтолтой. Гэтэл шүүх шийдвэр гаргахдаа баримталдаг тэр нотлох баримт нь баталгаат байдлын шалгуурыг хангахгүй бол энэ зүй тогтол алдагдана.

Шинжилгээний үр дүн хэргийн зүйлчлэл, байцаан шийтгэх ажиллагааны тодорхой үе шатанд шийдвэр гаргах үндэслэлийг тогтоох хууль зүйн чухал үр дагавар бүхий шинжлэх ухааны аргаар шалгагдсан баримтат мэдээлэл болно.¹⁰

Манай орны хууль зүйн онол, практикт шинжээчийн дүгнэлтийг үнэлэх, ялангуяа шүүхийн хэлэлцүүлгийн шатанд шинжээчийн дүгнэлтийг шинжлэх тусгай шалгуур өнөө хэр алга. Өмгөөлөгчид сүүлийн үед шинжээчийн дүгнэлт найдвартай эсэх, дүгнэлт гаргасан шинжээчийн тусгай мэдлэг хангалттай эсэх талаар шүүхийн шатанд шүүгч, прокурор нараас асуудаг болоод байна. Энэ нь шинжээчийн дүгнэлтэд тодорхой шалгуур байх ёстойг харуулсан зүй ёсны илрэл юм.

Шинжээчийн дүгнэлт үнэн зөв, найдвартай, баталгаатай гэж итгэх “дотоод итгэл” яаж төрөх вэ? Шинжээчийн дүгнэлт тодорхой шалгуур хангаж байвал тэрхүү итгэл төрнө. Шинжээчийн дүгнэлтийг хүн

¹⁰ Ж.Бямбаа. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд. УБ., 2008. 185 дахь тал.



МОНГОЛЫН
ХҮҮЛЬ САХИУЛАХ
УСТИСЫН
ХАМГААГАХ
ХАМГААГАХ
ХАМГААГАХ
ХАМГААГАХ

бүр дүр зоргоор, өөрийн үзэмжээр үнэлэх бус харин процесст оролцогчдоос хүлээн зөвшөөрсөн тодорхой шалгуураар үнэлэх нь зүйн хэрэг.

Шинжээчийн дүгнэлтэд хэрхэн шалгуур тавих вэ гэдэг асуудалд эрдэмтэд дараах байр суурьтай байдаг байна.

Ю.Г.Корухов: “шинжээчийн дүгнэлтийг нотлох баримтын хувьд үнэлэхэд найдвартай зөв дүгнэлт гарсан эсэхийг тогтоох нь тэргүүн зэргийн ач холбогдолтой”¹¹ гэж үзсэн нь дүгнэлт бусад нотлох баримттай тохирч байгаа гэдгээс илүү тухайн дүгнэлт өөрөө найдвартай юу гэдэгт анхаарлаа хандуулах нь чухал гэдгийг илэрхийлсэн байна.

В.К.Лисиченко үзэхдээ: “Шинжээчийн дүгнэлтийг арга зүйн талаас нь үнэлэхдээ мөрдөн байцаагч болон шүүх:

а/ шинжилгээний арга зүйг зөв сонгосон эсэх, тэдгээрийг дүгнэлтэд бүрэн дүүрэн тусгасан эсэх,

б/ явуулсан шинжилгээ, судалгаа нь асуусан асуудлыг шийдвэрлэх шаардлагыг хангаж байгаа эсэх, шинжилгээнд хэрэглэсэн техник хэрэгсэл, арга барил тусгагдсан эсэх, ямар үр дүн гарсан, тэдгээрийн үндэс шалтгаан,

в/ шинжилгээний үр дүнг иш үндэс болгоход шинжээчийн зүгээс ямар тусгай мэдлэг ашигласан болох,

г/ шинжээчийн дүгнэлт шинжилгээ хийж, хариулт өгөхөд хангалттай материал дээр тулгуурласан эсэх,

д/ хийсэн шинжилгээ тусгай мэдлэгийн хөгжлийн түвшин болон шүүхийн шинжилгээний төрөлд тохирч буй эсэх зэргийн магадлах ёстой”¹² гэж бичсэн байна.

Р.С.Белкин: “Мөрдөн байцаагч нь шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ:

а/ шинжилгээ хийлгэхэд бэлтгэх, шинжээч томилох ажиллагаа хуулийн дагуу явагдсан эсэхийг шалгах, хэрэв журам зөрчигдсөн бол үр дагаварт үнэлгээ өгөх,

б/ шинжилгээний материал, шинжилгээний хэрэгсэлд шинжээчийн мэргэжил, туршлага нийцэж буй эсэхийг шалгах,

в/ дүгнэлт бүрэн дүүрэн болсон эсэхийг шалгаж үнэлэх,

г/ дүгнэлтийн шинжлэх ухааны үндэслэлийг үнэлэх,

д/ шинжээчийн дүгнэлт ба тухайн хэргийн хамаарал, бусад нотлох баримт дахь эзлэх байр суурийг үнэлэх зэрэг ажиллагааг хийх ёстой”¹³ гэжээ.

АНУ-ын шүүхийн практикт “Даубертын стандарт” гэдэг ойлголт байдаг ба энэ нь шинжээчийн дүгнэлтийг шалгах 4 үзүүлэлт юм.

а/ Зөвхөн шүүгч үнэлэх. Шинжээчийн дүгнэлтийг гагцхүү шүүгч хүлээн зөвшөөрнө. Тэд тухайн шинжээчийн дүгнэлт шинжлэх ухааны мэдлэгт суурилсан гэдгийг шалгах ёстой.

б/ Хамааралтай байх. Шинжээч тухайн хэрэг маргаанд хамааралтай асуудалд дүгнэлт гаргасан байна.

в/ Найдвартай байх. Шинжилгээний арга, техник хангамж найдвартай байхын зэрэгцээ, практик хэрэглээгээр батлагдсан байна.

г/ Шинжлэх ухаанч мэдлэг: Шинжлэх ухааны мэдлэг нь хүчин төгөлдөр, үнэн байх ёстой. Шинжлэх ухааны арга зүй хүчин төгөлдөр байхын тулд:

- Энэ нь эмпирик шалгалт, хяналтад нээлттэй байх,
- Хянагдаж хэвлэгдсэн судалгааны ажилд суурилсан байх,
- Боломжит алдааны түвшин мэдэгдэж байх,
- Эрх бүхий субъект хянаж стандарт тогтоосон байх,
- Холбогдох шинжлэх ухааны хүрээлэн хүлээн зөвшөөрсөн байх.

Дээрхи шалгуурыг АНУ-ын Холбооны нотлох баримтын дүрмийн 701, 702 дугаар зүйлд баталгаажуулсан байдаг.

Канад Улсын нотлох баримтын эрх зүйн сурах бичигт шинжээчийн дүгнэлтийг нотлох баримтаар зөвшөөрөх үндсэн шалгуурыг тодорхойлж өгчээ.¹⁴ Үүнд:

1. Хамааралтай байх.
2. Үйл явдлыг хянан шийдвэрлэхэд зайлшгүй дэмжлэг болох.
3. Найдварт байдал.
 - а. Нийтлэг (гол) зарчим:
 - б. Шинэ шинжлэх ухаан, технологи-түүхэн уламжлалтай байх:
 - с. Орчин үеийн хандлагатай байх:
 - д. үнэн баталгаат шалгалтад суурилсан байх:

1. шинжээчийн онолын мэдлэг шинжилгээ хийх боломжтой эсэх (лиценз олгох):

¹¹ Ю.Г.Корухов. Достоверность экспертного заключения и пути совершенствования ее оценки //Вопросы теории судебной экспертизы. С.6.

¹² В.К.Лисиченко. Особенности проверки и оценки заключений экспертизы на предварительном следствии и в суде //Криминалистика и судебная экспертиза. Киев., 1982. Вып 24. С.33.

¹³ Р.С.Белкин. Собрание, оценка и исследование доказательств. М., 1966. С.287.

¹⁴ Alan W. Bryant, Sidney N. Lederman, Michelle K. Fuerst. The law of evidence in Canada. Third edition: 2009., 792-826 дахь тал.

2. онолын мэдлэгийг баталгаажуулж хянасан, хэвлэн нийтэлсэн эсэх;

3. онол болон технологийн боломжит алдааг тооцсон эсэх;

4. онолын мэдлэгийг холбогдох шинжлэх ухааны нийгэмлэг хүлээн зөвшөөрсөн эсэх.

Дүгнэлт

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 85 дугаар зүйлийн 85.4-т заасан “Шинжээчийн дүгнэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор шүүх заавал баримтлах үүрэггүй боловч дүгнэлтийг зөвшөөрөхгүй байгаа бол үндэслэлээ заасан байвал зохино” гэсэн заалтыг ухаж ойлговол хоёр утга илэрхийлж байна. Нэгдүгээрт, шинжээчийн дүгнэлтэд шууд итгэж болохгүй. Хоёрдугаарт, хэрэв дүгнэлтийг ашиглахгүй гэж байгаа бол ямар үндэслэлээр дүгнэлтийг үгүйсгэж байгааг тодорхойлох ёстой гэсэн ойлголт байна. Хэдийгээр хуульд ийм зохицуулалт байгаа боловч, нарийвчилсан тусгай шалгуурыг онолын хувьд ч, эрх зүйн хувьд ч, манай оронд тодорхойлсон нь үгүй байна.

Эрх зүйн аливаа зөрчил, маргааныг шийдвэрлэхэд шинжлэх ухаан, технологийн ололт амжилтыг ашиглах буюу тусгай мэдлэг, шинжээчийн дүгнэлтийн нотлох ажиллагаанд бусад нотлох баримтаас илүү үнэлэгдэж буй өнөө цагт шинжээчийн дүгнэлтийн найдвартай, баталгаат байдлыг үнэлэх ёстой ба энэ үүднээс шинжилгээний арга зүйг сайжруулах зайлшгүй шаардлагатай.

Санал

Шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд хууль зүй, шинжлэх ухаан, техник, хүний хүчин зүйлийн шалгуурыг харгалзах ёстой¹⁵.

Хууль зүйн шалгуурт:

1. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий субъект шинжилгээ хийлгэсэн байх;

2. Хэрэгт хамааралтай байх;

3. Шинжээчээс татгалзан гарах үндэслэлгүй байх;

4. Шинжээчид шинжилгээ хийхээс өмнө хууль тогтоомжид заасан эрх, үүргийг нь тайлбарлан өгч, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 254, 255-р зүйлд заасан хариуцлагыг сануулж, «Шинжилгээ хийлгэх тогтоол»-д гарын үсэг зуруулсан байх;

5. Шинжилгээний харьцуулах загварыг ЭБШХ-ийн 160 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулан шинжилгээнд хүргүүлсэн байх.

¹⁵ Б.Лхагвасүрэн. Криминалистикийн шинжилгээ судлал. УБ., 2010. 27 дахь тал.

Хүний хүчин зүйлийн шалгуурт:

1. Тусгай мэдлэг эзэмшсэн хүнийг шинжээчээр томилсон байх;

2. Тусгай мэдлэг хэрхэн эзэмшсэн болохыг харгалзах;

3. Хувь хүний туршлагыг харгалзах;

Шинжлэх ухааны шалгуур:

1. Шинжээчээс асуусан асуултад орчин үеийн шинжлэх ухааны арга, хэрэгсэл хариулт өгөх боломжтой байх.

2. Шинжилгээнд хүргүүлсэн зүйлс шинжээчээс асуусан асуултад хариулт өгөхөд хангалттай, боломжтой байх.

3. Шинжээч өөрийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд шинжилгээ хийсэн байх.

4. Шинжилгээний арга зүй, технологи шинжлэх ухааны үндэстэй, найдвартай байхын зэрэгцээ, баталгаажсан байх.

5. Шинжилгээ хийх тогтсон үе шатыг баримталсан байх.

6. Шинжилгээ хийх аргыг зөв сонгож, хослуулсан байх.

7. Шинжилгээнд шаардлагатай багаж, хэрэгслийг дүүрэн ашигласан байх.

8. Оношилгооны болон адилтгалын ач холбогдол бүхий шинж тэмдгүүдийн нийлбэр цогцыг үндэслэн дүгнэлтэд хүрсэн байх.

Техник шалгуур:

1. Монгол хэл, шинжилгээ судлалын тогтсон нэр томьёог хэрэглэсэн байх.

2. Утга, найруулга зүй, зөв бичих дүрмийн алдаагүй байх.

3. Дүгнэлтийн хуудас бүрд шинжээч гарын үсэг зурж, хувийн тэмдгээр баталгаажуулсан байх.

4. Гэрэл зургийн үзүүлэлтэд тайлбар, хаяг, тэмдэглэгээ хийсэн байх. Жич: зарим төрлийн шинжилгээний гэрэл зургийн үзүүлэлтэд тэмдэглэгээ хийхгүй байх талаар стандарт тогтоох.

Дээрх шалгуур үзүүлэлтээр Улсын Дээд Шүүх тогтоол гаргаж албан ёсны эрх зүйн акт тогтоох, процессын хууль тогтоомжид шинжээчийн дүгнэлтийг тусгай шалгуураар үнэлэх эрх зүйн үндсийг тодорхойлж өгөх шаардлагатай.

Ном зүй:

1. Alan W. Bryant, Sidney N. Lederman, Michelle K. Fuerst., The law of evidence in Canada., Third edition: 2009.

2. Белкин. Р.С., Собрание, оценка и исследование доказательств. М., 1966.

3. Бямбаа. Ж., Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд., УБ., 2008.



МОНГОЛЫН
ХҮҮЛЬ САХИУЛАХ
УЛСЫН
ХҮҮЛЬ САХИУЛАХ
УЛСЫН

4. Корухов. Ю.Г., Достоверность экспертного заключения и пути совершенствования ее оценки // Вопросы теории судебной экспертизы.

5. Лисиченко. В.К., Особенности проверки и оценки заключений экспертизы на предварительном следствии и в суде // Криминалистика и судебная экспертиза., Киев., 1982., Вып 24.

6. Лхагвасүрэн. Б., Криминалистикийн шинжилгээ судлал., УБ., 2010.

7. "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны №6 дугаар.

8. Хамтын бүтээл., Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар., УБ., 2003.

9. ЦЕГ-ын Мэдээлэл судалгааны төвөөс гаргасан 2014-2016 оны гэмт хэргийн статистик мэдээ.

10. ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс гаргасан 2014-2016 оны Шүүхийн үйл ажиллагааны тайлан.

11. ШШҮХ-ийн 2009-2016 оны тайлан.